



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/219/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

**БААЦАГААН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Д.БОЛОРМАА ТАНАА**

2024.02.23 № 2/39

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 49/A/119 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцон гүйцэтгэлээр санхүүжиж Эрүүл мэндийн даатгалын сангаас 645,413.2 мянган төгрөгийн санхүүжилт авч 9,038.8 мянган төгрөгийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг мөрдсөн байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020049

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай тайлагнаж дээд шатны байгууллагаас 92.1 хувьтай дүгнэсэн байна.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	178,858,178.16	147,733,998.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,414,971.10	5,710,172.56
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	33,414,971.10	5,710,172.56
31210	Төгрөг	33,414,971.10	5,710,172.56
31211	Төрийн сангийн харилцах	33,414,971.10	5,710,172.56
33	АВЛАГА	4,826,485.89	15,962,104.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	15,962,104.00
33500	Бусад авлага	4,826,485.89	0
33510	Байгууллагаас авах авлага	4,826,485.89	0
35	БАРАА МАТЕРИАЛ	140,616,721.17	126,061,722.07
35100	Түүхий эд материал	41,506,478.27	25,592,483.32
35130	Эм боох материал	41,506,478.27	25,592,483.32
35400	Хангамжийн материал	99,110,242.90	100,469,238.75
35410	Бичиг хэргийн материал	454,000.00	556,500.00
35420	Аж ахуйн материал	86,096,733.30	89,555,779.15
35460	Хүнсний материал	766,870.00	486,305.00
35470	Бусад хангамжийн материал	11,792,639.60	9,870,654.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,174,260,569.13	1,157,725,562.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,174,260,569.13	1,157,725,562.76
39200	Биет хөрөнгө	1,166,268,369.13	1,149,297,029.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,122,738,491.03	852,235,107.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-115,275,858.70	-103,684,370.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,090,000.00	255,202,238.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,061,166.93	-26,088,833.46
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	196,372,347.54	243,443,927.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,743,145.16	-148,694,947.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,428,622.26	87,428,622.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,388,097.16	-22,098,302.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,560,880.25	20,560,880.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,453,704.00	-9,007,292.02
39300	Биет бус хөрөнгө	7,992,200.00	8,428,533.32
39301	Програм хангамж	0	467,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-31,166.68
39303	Бусад биет бус хөрөнгө	8,442,200.00	8,442,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,353,118,747.29	1,305,459,561.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,082,704.64	5,526,047.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,082,704.64	5,526,047.00
41300	Өглөг	6,082,704.64	5,526,047.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,607.89	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,404,046.75	5,526,047.00

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41360	Бусад өглөг	666,050.00	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	666,050.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,347,036,042.65	1,299,933,514.39
51	Засгийн газрын хувь оролцоо	1,347,036,042.65	1,299,933,514.39
51100	Засгийн газрын оруулсан капитал	457,476,951.22	457,476,951.22
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	457,476,951.22	457,476,951.22
51200	Хуримтлагдсан үр дүн	673,654,641.05	693,144,900.14
51210	Өмнөх үеийн үр дүн	-511,970,732.61	740,247,428.40
51220	Тайлант үеийн үр дүн	1,185,625,373.66	-47,102,528.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	215,904,450.38	149,311,663.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,353,118,747.29	1,305,459,561.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,920,495,204.80	985,153,139.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,285,039,694.80	275,726,387.86
120	Нийтлэг татварын бус орлого	1,285,039,694.80	275,726,387.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,400,000.00	15,004,560.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	4,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400,000.00	15,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,175,802,969.19	245,961,618.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	107,836,725.61	14,760,209.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	635,455,510.00	709,426,751.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,052,500.00	48,051,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,052,500.00	48,051,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	596,403,010.00	661,375,351.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	596,403,010.00	661,375,351.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	734,869,831.14	784,277,693.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	734,869,831.14	784,277,693.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,090,432.14	758,788,969.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,475,015.46	454,839,252.08
210101	Үндсэн цалин	364,839,800.41	250,910,059.52
210102	Нэмэгдэл	13,202,291.89	152,365,111.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	489,000.40	6,944,000.00
210104	Урамшуулал	943,922.76	44,620,081.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,445,086.23	58,154,407.49

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	33,416,004.37	40,332,655.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,046,281.86	4,639,336.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,661,800.00	3,920,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	667,100.00	815,848.15
210205	Эрүүл мэндийн даатгал	6,653,900.00	8,445,667.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,998,101.00	41,772,676.02
210301	Гэрэл, цахилгаан	2,847,901.00	3,968,276.02
210302	Түлш, халаалт	31,586,800.00	36,404,400.00
210303	Цэвэр, бохир ус	563,400.00	1,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,937,175.00	43,790,756.35
210401	Бичиг хэрэг	4,520,850.00	3,609,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,101,025.00	24,397,885.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,556,800.00	1,620,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	2,491,070.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,113,500.00	7,075,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	4,596,000.00
2105	Нормативт зардал	100,031,657.39	108,102,145.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,220,022.39	91,640,330.77
210502	Хоол, хүнс	15,811,635.00	16,101,815.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,720,000.00	6,921,836.06
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	250,636.06
210604	Урсгал засвар	1,720,000.00	6,671,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,670,000.00	4,444,200.00
210702	Дотоод албан томилолт	1,670,000.00	4,444,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,362,672.00	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,062,672.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,450,725.06	40,763,695.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,734,425.00	6,736,235.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,716,300.06	34,027,460.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,779,399.00	25,488,723.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	22,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	22,160,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,779,399.00	3,328,723.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,779,399.00	3,328,723.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,185,625,373.66	200,875,445.51
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	247,977,973.77

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	243,336,563.77
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	4,641,410.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,185,625,373.66	-47,102,528.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Г/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	814,298,510.00	708,469,207.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,400,000.00	15,004,560.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,400,000.00	15,004,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,400,000.00	15,004,560.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	4,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400,000.00	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	812,898,510.00	693,464,647.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,052,500.00	48,051,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,052,500.00	48,051,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	773,846,010.00	645,413,247.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	773,846,010.00	645,413,247.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	712,709,638.90	721,306,605.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,709,638.90	721,306,605.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,930,239.90	695,817,881.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,927,646.84	454,851,859.97
210101	Үндсэн цалин	255,938,593.14	238,580,653.07
210102	Нэмэгдэл	82,808,263.16	164,707,125.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,059,000.00	6,944,000.00
210104	Урамшуулал	38,121,790.54	44,620,081.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,643,086.23	58,028,043.42
210201	Тэтгэврийн даатгал	31,979,786.23	40,149,871.59
210202	Тэтгэмжийн даатгал	3,742,300.00	4,639,336.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,993,800.00	3,920,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	748,500.00	872,267.78
210205	Эрүүл мэндийн даатгал	7,178,700.00	8,445,667.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,138,101.00	41,772,676.02
210301	Гэрэл, цахилгаан	2,847,901.00	3,968,276.02
210302	Түлш, халаалт	31,586,800.00	36,404,400.00
210303	Цэвэр, бохир ус	703,400.00	1,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,750,985.62	35,217,385.60
210401	Бичиг хэрэг	3,967,700.00	3,715,500.00
210402	Тээвэр, шатахуун	28,101,025.00	24,397,885.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,111,800.00	1,512,000.00

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,025,000.00	2,227,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,545,460.62	3,365,000.00
2105	Нормативт зардал	73,402,087.00	84,852,766.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,719,737.00	64,655,466.75
210502	Хоол, хүнс	14,172,350.00	15,197,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,613,000.00	9,439,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,241,000.00	0
210604	Урсгал засвар	21,372,000.00	9,439,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,670,000.00	4,444,200.00
210702	Дотоод албан томилолт	1,670,000.00	4,444,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,295,758.21	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,995,758.21	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,489,575.00	7,211,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,489,575.00	7,211,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,779,399.00	25,488,723.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	22,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	22,160,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,779,399.00	3,328,723.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,779,399.00	3,328,723.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	101,588,871.10	-12,837,398.54
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	68,173,900.00	14,867,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,173,900.00	14,867,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	68,173,900.00	14,867,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,173,900.00	14,867,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-68,173,900.00	-14,867,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	33,414,971.10	-27,704,798.54
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	33,414,971.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,414,971.10	5,710,172.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	457,476,951.22	215,904,450.38	-511,970,732.61	161,410,668.99

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-511,970,732.61	161,410,668.99
3	Тайлант үеийн үр дүн	0	0	1,185,625,373.66	1,185,625,373.66
4	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	673,654,641.05	1,347,036,042.65
5	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	673,654,641.05	1,347,036,042.65
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	66,592,787.35	66,592,787.35
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	740,247,428.40	1,413,628,830.00
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-66,592,787.35	0	-66,592,787.35
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-47,102,528.26	-47,102,528.26
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	149,311,663.03	693,144,900.14	1,299,933,514.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	794,268,200.00	732,845,281.76	-61,422,918.24	92.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	794,268,200.00	732,845,281.76	-61,422,918.24	92.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	772,068,200.00	710,685,281.76	-61,382,918.24	92.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	490,672,000.00	454,851,859.97	-35,820,140.03	92.70
210101	Үндсэн цалин	246,214,700.00	238,580,653.07	-7,634,046.93	96.90
210102	Нэмэгдэл	190,134,800.00	164,707,125.34	-25,427,674.66	86.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,346,000.00	6,944,000.00	1,598,000.00	129.89
210104	Урамшуулал	48,976,500.00	44,620,081.56	-4,356,418.44	91.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,434,400.00	58,028,043.42	-3,406,356.58	94.46
210201	Тэтгэврийн даатгал	41,775,100.00	40,149,871.59	-1,625,228.41	96.11
210202	Тэтгэмжийн даатгал	4,914,800.00	4,639,336.86	-275,463.14	94.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,931,600.00	3,920,900.00	-10,700.00	99.73
210204	Ажилгүйдлийн даатгал	983,300.00	872,267.78	-111,032.22	88.71
210205	Эрүүл мэндийн даатгал	9,829,600.00	8,445,667.19	-1,383,932.81	85.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,051,400.00	41,772,676.02	-3,278,723.98	92.72
210301	Гэрэл, цахилгаан	6,606,200.00	3,968,276.02	-2,637,923.98	60.07
210302	Түлш, халаалт	37,005,200.00	36,404,400.00	-600,800.00	98.38
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.00	1,400,000.00	-40,000.00	97.22
2104	Хангамж, бараа материалын зардал	42,993,100.00	35,217,385.60	-7,775,714.40	81.91
210401	Бичиг хэрэг	5,165,800.00	3,715,500.00	-1,450,300.00	71.92

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	29,940,600.00	24,397,885.60	-5,542,714.40	81.49
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,512,000.00	1,512,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,999,700.00	2,227,000.00	-772,700.00	74.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,375,000.00	3,365,000.00	-10,000.00	99.70
2105	Нормативт зардал	88,015,100.00	84,852,766.75	-3,162,333.25	96.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,582,700.00	64,655,466.75	-2,927,233.25	95.67
210502	Хоол, хүнс	15,432,400.00	15,197,300.00	-235,100.00	98.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,499,200.00	23,439,000.00	-60,200.00	99.74
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.00
210602	Тавилга	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	9,499,200.00	9,439,000.00	-60,200.00	99.37
2107	Томилолт, зочны зардал	5,750,000.00	4,444,200.00	-1,305,800.00	77.29
210702	Дотоод албан томилолт	5,750,000.00	4,444,200.00	-1,305,800.00	77.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,653,000.00	8,079,350.00	-6,573,650.00	55.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,653,000.00	8,079,350.00	-6,573,650.00	55.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,200,000.00	22,160,000.00	(40,000.00)	99.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,200,000.00	22,160,000.00	(40,000.00)	99.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,200,000.00	22,160,000.00	-40,000.00	99.82
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	806,797,377.36	656,638,408.20	150,158,969.16	81.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,051,400.00	-3,779,399.00	-51,830,799.00	-7.87
132001	Орон нутгийн төсвөөс	48,051,400.00	-3,779,399.00	-51,830,799.00	-7.87
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	743,745,977.36	645,413,247.20	-98,332,730.16	86.78
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	743,745,977.36	645,413,247.20	-98,332,730.16	86.78
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	4,560.00	4,560.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,560.00	4,560.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	33,414,971.10	33,414,971.10	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	5,710,172.56	5,710,172.56	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.00	27.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.00	27.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21.00	21.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чанартай хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлсон байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Эрүүл мэндийн төв нь 27 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны байдлаар нийт хэвтэн эмчлүүлэгсэд 229, дундаж ор хоног 6.5 хувь. эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 4926 хүн хамрагдаж үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 2163 хүн хамрагдсан эмчлүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Эрүүл мэндийн төвийн дарга Д.Болормаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Н.Үүрцайх нар зурж, нярваар М.Хандсүрэн нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 695.036.9 мянган төгрөгөөр буюу 82.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	33,414.9	9038.8	-24,376.10
Авлага	4,826.4	15,962.10	11,135.70
Бараа материал	140,616.70	126,061.7	-14,555.00
Үндсэн хөрөнгө	1,174,260.50	1,157,725.50	-16,535.00
хуримтлагдсан элэгдэл	-318,371.90	-310,054.90	8,317.00
Нийт хөрөнгө	1,353,118.70	1,308,788.20	-44,330.50
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,347,036.00	1,303,262.20	-43,773.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,353,118.70	1,308,788.20	-44,330.50

Эх сурвалж: Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 33,414.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 9,038.8 мянган төгрөг болж өмнөх оноос 24,376.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 16,535.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 13,399.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,000.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 467.5 мянган төгрөгийн программ хангаж худалдан авсан байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас 207,312.2 мянган төгрөгийн Nissan Patrol Y61 маркийн тээврийн хэрэгсэл, 7,316.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн ЗДТГ-аас 31,333.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Тайлант хугацаанд 285,681.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 сарын 13-ны өдрийн 13/08 тоот тогтоолоор акталж данс бүртгэлээс хассан байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 14,555.0 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагаанд 135,403.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, даргын 2023.06.30-ны өдрийн 15, 2023.12.31-ний өдрийн 48 дугаар тушаалаар 25,885.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж дансны үлдэгдэл нь 126,061.7 мянган төгрөг байна.

Тайлант онд авлага 11,135.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Тайлант онд 5,526.0 мянган төгрөгийн эмийн өглөгтэй гарсан нь байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 43,773.8 мянган төгрөгөөр буурч, 1,303,262.20 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 66,592.7 мянган төгрөгөөр буурсан, өмнөх үеийн үр дүн 66,592.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 740,247.4 мянган төгрөг болсон байна. Энэ нь дахин үнэлгээний үлдэх өртөгтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 866,863.1 мянга төгрөг, орон нутгийн төсвөөс 65,523.4 мянган төгрөг нийт 932,386.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 188,878.6 мянган төгрөгөөр бууруулан 677,984.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбоотой 1 удаа төсөвт өөрчлөлт оруулж 65,761.4 мянган төгрөгөөр тодотгож санхүүжилт нэмж олгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 743,745.9 мянган төгрөг санхүүжилтийн төлөвлөгөө батлагдсан гүйцэтгэлээр 734,707.0 мянга, орон нутгийн төсвөөс 48,051.4 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 688,122.6 мянган төгрөгийг зарцуулж, 5,710.1 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталснаас 48,051.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.7 хувь буюу 44,722.7 мянган төгрөгийг зарцуулж 3,328.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Код	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	489,251.10	443,124.30	46,126.80	90.57
2	81603	үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	208,600.70	200,286.51	8,314.19	96.01
3	83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	48,415.00	44,711.80	3,703.20	92.35
4	80112	Нийтлэг үйлчилгээ	48,051.40	48,051.40	-	100.00
Нийт			794,318.20	736,174.01	58,144.19	92.68

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн газрын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 зугаар улирлын нийт зардлын 782,078.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,820.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 5,865.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 497,359.4 мянган төгрөгийн 26

гүйлгээ, зарлагын 241,214.5 мянган төгрөгийн 12 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Номгон аудит” ХХК-ийн аудитор Г.Саранчимэг, аудиторын туслах Б.Оргилбаяр нар гүйцэтгэж, менежментийн захидлаар 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	8,430.0	2	8,430.0	100.00%
Албан шаардлага	1	5,404.0	1	5,404.0	100.00%
Нийт дүн	1	13,834.0	1	13,834.0	100.00%

Эх сурвалж: Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023.05.23-ны өдрийн 55 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.23-нй өдөр 55 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд эмийн зардалд 67,582.7 мянга, шатахууны зардалд 29,940.6 нийт 97,523.3 мянган төгрөг батлагдаж зарцуулагдсан ба төлөвлөлт, гүйцэтгэлийг дараагийн аудитаар үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил дутагдал илрээгүй.



Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--